

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /5-р сарын 29-нөөс 6-р сарын 25-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	V/29	VI/05	VI/12	VI/19	VI/25
1	Гурил, I зэрэг, кг	650	650	650	650	650
2	Хонины мах, кг/ ястай/	7800	7800	7800	7500	7500
3	Үхрийн мах, кг /ястай/	11000	10000	зарагдаагүй	9500	9500
4	Ямааны мах /ястай /	6500	6500	6500	6000	6000
5	Элсэн чихэр, кг	1480	1480	1480	1480	1480
6	Цагаан будаа, кг	1600	1600	1600	1600	1600
7	Шингэн сүү, л	900	900	800	800	700
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан	58000	60000	60000	60000	зарагдаагүй
9	- Бор ноолуур	58000	60000	60000	60000	зарагдаагүй
10	Бензин, А-80, 1 литр	1600	1600	1550	1550	1550
11	Бензин, А-92, 1 литр	1700	1700	1650	1650	1650
12	Дизелийн түлш, 1 литр	1800	1800	1750	1750	1750

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2013 оны 5-р сарын 29-нөөс 6-р сарын 25-ны хооронд гурил, элсэн чихэр, цагаан будааны үнэ тогтвортой байж бусад бараа бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдөв.

**Махны үнэ.** Үхрийн ястай мах 5-р сарын 29-нд 11000 байсан бол 6-р сарын 5-нд 1000 төгрөгөөр буурч 10000 төгрөг, 6-р сарын 19, 25-нд 9500 төгрөг болж 6-р сарын 5-наас 5%-аар буурав. Хонины ястай мах 1 кг нь 6-р сарын 12-ныг хүртэл 7800 төгрөгийн ханштай байсан бол 6-р сарын 19-нөөс 3,8%-аар буурч 7500 төгрөг болов. Ямааны ястай мах мөн 6-р сарын 19-нд өмнөх 7 хоногийн ханштай харьцуулахад 7,7%-аар буурч 6000 төгрөг болов.

Шингэн сүүний үнэ тогтмол буурсаар байгаа ба 6-р сарын 25-нд 700 төгрөг болж өмнөх 7 хоногоос 100 төгрөгөөр буурав.

Ямааны ноолуур бор, цагаан өнгө ялгалгүй ижил үнэтэй байгаа ба дээд ханш 6-р сарын 05, 12, 19-ний өдөр 60000 төгрөгт хүрч 5-р сарын 29-ы ханшаас 3,45 хувиар өсөв. 6-р сарын 25-нд ноолуурын арилжаа хийгдсэнгүй.

Шатахууны үнэ 6-р сарын 19-нд өмнөх 7 хоногоос төрөл тус бүр 50 төгрөгөөр буурсан.





